



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**  
Төрийн Өмчит Хувьцаат Компани

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 12 өдөр

Дугаар А/4

Улаанбаатар хот

### Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6.1, 7.6.2, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, Хөдөлмөрийн дотоод журмын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг Гүйцэтгэх захиралд улирал бүр тайлагнаж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга М.Гантөгсөд үүрэг болгосугай.


3. Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг зохих эх үүсвэрээс санхүүжүүлэхийг ерөнхий нягтлан бодогч Б.Ганбатад зөвшөөрсүгэй.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.БАТСАЙХАН

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 4/ дугаар тушаалын хавсралт



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК-ИЙН 2015 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийх ажлын агуулга, эрх зүйн үндэслэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа		Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан	Бусад тайлбар	
1.	<p>Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх,</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг байгууллагын хэмжээнд сурталчлах, мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх</p>	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлах		02/15-ны дотор	ЭБАТ		
			Төлөвлөгөөг хамт олонд сурталчлах, таниулах	1-р улиралд	ЭБАТ		
			Мэдээллийн самбар ажлын байранд ажиллуулах				
			Компанийн цахим хуудсанд холбогдох буланг тогтмол ажиллуулах	тайлант хугацаанд	Олон нийттэй харилцах ажилтан		
		<p>Эрх зүйн үндэслэл:</p> <p>Авлигын эсрэг хууль /АЭХ/-ийн 5.1.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль /ГХУСТХ/-ийн 7.5, 7.6.1, 7.6.2, 9.1.2;</p>	Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	АТГ-аас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг хамт олонд сурталчлах	тайлант хугацаанд	ЭБАТ	
	Эрх бүхий төрийн байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авах						
				Компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээллийн ил тод байдлыг хангах	тайлант хугацаанд	Олон нийттэй харилцах ажилтан,	Эдийн засагч
			Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах				



		Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах	АТГ-т	11/15-ны дотор	ЭБАТ	
2.	Төсвийн орлого, зарлага, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх  <i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9-р зүйл	Урт хугацааны зээлийн эргэн төлөлт, түүний хуваарийг ил тод мэдээлэх		тайлант хугацаанд	Санхүүгийн хэлтэс	
		Компанийн 2014 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг цахим хуудсанд мэдээлэх				
		Компанийн 2015 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төсөл, холбогдох шийдвэр, орсон нэмэлт өөрчлөлтийг цахим хуудсанд байршуулах				
		2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсанд байршуулах				
		Жилийн эцсийн санхүүгийн тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, СЗХ-нд хуулийн хугацаанд хүргүүлэх		хуулийн хугацаанд		
		Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг нийтэд ил тод мэдээлэх				
		2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, түүнд оруулсан өөрчлөлтийг цахим хуудсанд байршуулах				
		Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах				
		Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх		тухай бүр		
		Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг нийтэд ил тод мэдээлэх		улирал бүр		

3.	<p>Хүний нөөцийн ил тод байдлын хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p><i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн 6.1.5 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 8-р зүйл</p>	<p>Ажилтан сонгон шалгаруулах журмыг цахим хуудсанд байршуулах</p>	тайлант хугацаанд	Захиргааны хэлтэс Хүний нөөцийн алба	
		<p>Ажлын байрны сонгон шалгаруулалтын зарыг нийтэд ил тод мэдээлэх, мэдээллийн архив үүсгэн хадгалах</p>			
		<p>Компанийн цахим хуудсанд “Хүний нөөц” буланг тогтмол ажиллуулах, нээлттэй ажлын байрны зарыг байршуулах, харилцаа холбоо тогтоох шуурхай нөхцөлийг бүрдүүлэх</p>			
4.	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах</p> <p><i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн 6.1.4, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 10-р зүйл ТБОНӨХБАҮХАТХ-ийн 21-р зүйл, 47.4, 48.5</p>	<p>Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах</p>	хуулийн хугацаанд	Санхүүгийн хэлтэс	
		<p>Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан тендерийн урилгыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, e-procurement.mn болон компанийн цахим хуудсанд байршуулах</p>	тухай бүр		
		<p>Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлэх</p>	тухай бүр		
		<p>Тендер шалгаруулалтын үр дүнг procurement.mn болон компанийн цахим хуудсанд ил тод мэдээлэх</p>	тухай бүр		
		<p>Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг нээлттэй мэдээлэх</p>	тухай бүр		
		<p>Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг мэдээлэх</p>	тухай бүр		
	<p>Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг</p>	тайлант хугацаанд			



		оролцуулах			
		Тендерийг үнэлэх явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаар мэдэгдлийг тухай бүр гаргуулан авах, холбогдох мэдээллийн санд бүртгүүлэх	тухай бүр	ЭБАТ	
5.	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	Батлагдсан бүтэц, орон тооны дагуу ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж мөрдүүлэх	2-р улиралд	Захиргааны хэлтэс, Хүний нөөцийн алба	
	<i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн 6.1.6	Хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсанд нээлттэй байршуулах	тайлант хугацаанд		
6.	Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах	Компанийн албан тушаалтнуудын ХАСХОМ мэдүүлэг болон бусад мэдэгдэл, тайлбарыг АТГ-ын цахим санд тухай бүр оруулах	тухай бүр	ЭБАТ,	
		Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцох	тус бүр тайлант жилд 1-ээс доошгүй удаа	Олон нийттэй харилцах ажилтан	
	<i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн 6.1.7, 6.1.13 ГХУСТХ-ийн 7.6.3	Авлигатай тэмцэх газраас мэргэжил, арга зүйн туслалцаа авах			
7.	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	Ёс зүйн дүрмийг нийт хамт олонд танилцуулах, сурталчлах, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	тайлант хугацаанд	Захиргааны хэлтэс, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	
	НАНБХАСЗАСЗУСТХ-ийн 7.2.1, 7.1.2, 7.2.4, 7.2.5, 10-22 дугаар зүйл АЭХ-ийн 6.1.9, 6.8, 6.1.6	Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах тогтмол утас ажиллуулах, холбоо барих хаягийг цахим хуудсанд байршуулах		Олон нийттэй харилцах ажилтан	

8.	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	Компанийн дотоод болон гадаад орчинд давхар эрхлэх боломжтой ажил, албан тушаалыг холбогдох судалгааг үндэслэн тодорхойлох,	2-р улиралд	Захиргааны хэлтэс, хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	
	<i>Эрх зүйн үндэслэл:</i> НАНБХАСЗУСТХ-ийн 7.2.6, 19-р зүйл	Хөдөлмөрийн гэрээнд давхар ажил эрхлэлтийн талаар холбогдох заалтыг нэмэлтээр оруулах	1-р улиралд		
9.	Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах	Төрийн Өмчийн Хороо, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, шийдвэрийг компанийн цахим хуудсанд байршуулах	тайлант хугацаанд	ТУЗ нбд	
	<i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуудийн 6.1.10, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.4, 9.1.5	Төрийн Өмчийн Хороо, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлыг шийдвэрийг Төрийн Өмчийн Хороо, Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах			
		Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудсанд байршуулах		хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	
10.	Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлүүлэх шат дамжлагыг цөөрүүлэх зөрчлийн талаар мэдээллийг хүлээн авч шалгах	Компанийн цахим сайтад компанийн хаяг, холбоо барих утас, цахим хаягийг байршуулах, мэдээлэл, санал хүсэлт оруулах нөхцөлийг бүрдүүлэх	тайлант хугацаанд	Олон нийттэй харилцах ажилтан	
		Компанийн фэйсбүүк, твитер буланг тогтмол ажиллуулах			
	<i>Эрх зүйн үндэслэл:</i> Авлигын эсрэг хуулийн	Ирсэн гомдол, хүсэлт, санал сэтгэгдлийн бүртгэл хөтлөх, шийдвэрлэлтийг тайлагнах			



	6.1.11 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.2 НАНБХАСЗУСТХ-ийн 7.2.3	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал эрхэлсэн ажилтны нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утсыг нийтэд нээлттэй мэдээлэх	тайлант хугацаанд		
11.	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах  АЭХ-ийн 6.1.12, ГХУСТХ-ийн 9.1.1	Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаалын жагсаалтыг гаргах, жагсаалт дахь албан тушаалтан ХАСХОМ мэдүүлэх	02/15-ны дотор	ЭБАТ	
12.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх  Эрх зүйн үндэслэл: Авлигын эсрэг хуулийн 6.6, 6.7. 18.4.2, 29.4, ГХУСТХ-ийн 9.2		тайлант хугацаанд	ЭБАТ	